

БУГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭГДЭЛ

Бугд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар ард түмнийхээ зүй ёсны шудрага дургуйцлийг илэрхийлэн БНМАУ-ыг гадуурхан узэх бодлогыг колониологч империалист гурнууд юуны өмнө АНУ-ын зүгээс дахин гаргасныг эрс шийдвэртэйгээр буруушааж байна. Энэ оны 12-р сарын 4-нд НҮБ-ын Дюулгүйн Зөвлөлийн хуралдаанаар БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудлыг хэлэлцсэн байна. Энэ хуралдаан, дээр Америкийн Холбоот Улс ба түүнийг НАТО-тийн шугамаар аялдан дагалдагч хань хамсаатан болох Англи, Франц, Италийн төлөөлөгчид Чан Кай-шигийн тоглоомын дээрэмчдийнхээ хамт БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудлыг хэлэлцүүлэхгүй болгон саатуулав. Ингэснээрээ тэд колониологч шившигт нуур царайгаа даян дэлхийн өмнө дахин илчлэн харуулснаар үл барам энх тайвныг мереедегч их, бага улс гурэн бухний түгээмэл байгууллага болох НҮБ-ын үндсэн зарчим, агуу их зорилгыг бүдуулэг бөгөөд балмадаар зерчлее.

Империалист гурнууд, эн тэргүүнээ АНУ-ын гадуурхах бодлогын балгаар, мөн түүнчлэн бүх дэлхийн өмнө нэр хүндээ бурмесен барж ард түмнийхээ аливаа дэмжлэгээс үүрд хагацсан Чан Кай-шигийн булгийхэн НҮБ-ын бүх байгууллагад хууль бусаар бүгшиж оршиж байгаагийн уршгаар НҮБ-ын гишүүн болох БНМАУ-ын шудрага хүсэл нь 14 жилийн турш сунжирч одоо хуртэл биелэхгүй байна.

Өргөн уудам Ази, Африк тэвүүдэд тусгаар тогтносон шинэ улсууд удаа дараагаар төрөн гарч есен бойжих байгаа ба үндсэнийхээ тусгаар

тогтол хөгжил дэвшилийн телес Латин Америкийн ард түмний хеделгэен
ернем бэхжих байгаа, капитализмын бурэн уналт, колониализмын
буцалтгуй мөхөлтийн үе болох манай энэ эрэн үед энх тайванч улс
түмний эрхийг ерөнхийд нь угүйсэн үзэх ба тухайлбал БНМАУ-ын
хувьд колоничлогч ёсны дээрэнгүйлэн угүйсгэх бодлогыг баримтлах
явдал бол манай агуу их эрэн үеийн түүхийн хурдийг буцааж эр-
гүүлэх гэсэн империалист харгисуудын арчаагаа барсан оролдлого мен.

1946 оноос эхлэн БНМАУ-ын застийн газраас энэ байгууллагын
тишуунд элсэн орох асуудлын талаар удаа дараа тавьж байсан бух
ерегдлүүдээ хүчинтэй гэх Монголын ард түмэн, түүний Засгийн Газар
үзэж байна.

Хүнтэй холбогдуулан, НҮБ-ын төрөл бурийн байгууллагат Чан Кай-
шигийхэн зүй бусаар бутших байгаа нь НҮБ-д Бүгд Найрамдах Хятад
Ард Улсын хууль ёсны эрхийг сэргээх болон БНМАУ-ыг энэ байгууллагын
тишуунд элсүүлэх явдалд саад болж байгаа ба НҮБ-ыг империалистууд
явлцуу сонирхолдоо ашиглан улмаар түүнийг АНУ-ын Засгийн Газрын
дуулгавартай зэвсэг болгож байгаа нь бух дэлхийн улс түмний нудийн
емне олон улсын энэ их байгууллагын нэр хүндийг унагааж байгаа
хэрэг гэж үздгээ БНМАУ-ын Засгийн Газар мэдэгдэж байна. НҮБ-ын
байгууллага бүрээс Чан Кай-шигийхнийг нэн даруй хөсн зайлцуулж
энэ байгууллагат хууль ёсоор эзлэх байр суурийг нь Бүгд Найрамдах
Хятад Ард Улсад тавьж ехийг БНМАУ-ын Засгийн Газар шаардаж байна.

Хөгжил цэцэглэлтийн замаар дэвшиж хөгжж яваа бурэн эрхт,
тустаар тогтиносон Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Нэгдсэн
Үндэстний Байгууллагын гишүүнд элсүүлэн авахыг Монгол Улсын
Засгийн Газар ард түмнийхээ нэрийн емнеес шаардаж байна.

Даян дэлхийн энх тайванч ард түмнүүд, харгис тураангий
империализм, ард түмэнд жигшигдсэн колониализмын эсрэг тэмцэж
байгаа Ази, Африк, Латин Америкийн ард түмнүүд дээр дурдсан
баримтын талаар биднийг зүй ёсоор дургүйцэж байгааг зөвшөөрөн
хулээж БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнд элсүүлэх чин эрмэлзлэлийг
биелүүлэхэд шийдвэртэй дэмжилгээ узуулна гэдэгт Монголын ард
түмэн, түүний Засгийн Газар итгэж найдаж байна.

Улаанбаатар, 1960 оны 12-р сарын 6.